

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“УС-ДУ” ОНӨААТҮГ-ын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2026/002/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179, Цахим хаяг: <a href="mailto:sarantuyab@audit.gov.mn">sarantuyab@audit.gov.mn</a> Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: <a href="mailto:naranbayarg@audit.gov.mn">naranbayarg@audit.gov.mn</a> Аудитор: С.Батцэцэг Цахим хаяг: <a href="mailto:battsetsegsa@audit.gov.mn">battsetsegsa@audit.gov.mn</a>
Говьсүмбэр аймаг 2026 он	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу..

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
“УС-ДУ” ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Б.ГАНЗОРИГ ТАНАА

2026.03.25 № 54  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4228050243

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>288,201,065.17</b>	<b>1,256,312,475.66</b>
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	42,637,745.82	21,892,062.99
1.1.2	Банкин дахь мөнгө	29,076,863.98	13,603,360.53
1.1.3	Касс дахь мөнгө	13,560,881.84	8,288,702.46
1.1.4	<b>АВЛАГА</b>	<b>148,283,561.29</b>	<b>850,146,965.58</b>
1.1.5	Байгууллагаас авах авлага	86,012,210.09	760,898,894.24
1.1.6	Хувь хүмүүсээс авах авлага	51,634,461.13	79,100,551.29
1.1.7	Татвар, НДШ – ийн авлага	1,465,972.30	2,992,811.76
1.1.8	Бусад авлага	9,170,917.77	7,154,708.29
1.1.9	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>97,279,758.06</b>	<b>384,273,447.09</b>
1.1.10	Бараа материал	97,279,758.06	384,273,447.09
<b>1.1.12</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>288,201,065.17</b>	<b>1,256,312,475.66</b>
<b>1.2</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>6,714,040,724.71</b>	<b>7,431,455,595.99</b>
1.2.1	Барилга, байгууламж, орон сууц	6,059,981,843.98	6,283,533,406.13
1.2.2	Хуримтлагдсан элэгдэл	(1,364,400,095.82)	(1,509,540,199.13)
1.2.3	Авто-тээврийн хэрэгсэл	521,502,499.84	1,144,502,499.84
1.2.4	Хуримтлагдсан элэгдэл	(209,971,041.62)	(283,099,291.58)
1.2.5	Машин тоног төхөөрөмж	3,020,407,810.41	3,370,638,293.54
1.2.6	Хуримтлагдсан элэгдэл	(1,354,367,582.09)	(1,603,524,840.37)
1.2.7	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,065,658.82	30,065,658.82
1.2.8	Хуримтлагдсан элэгдэл	(11,113,617.67)	(14,137,325.55)
1.2.9	Компьютер бусад хэрэгсэл	43,481,590.54	21,530,489.00
1.2.10	Хуримтлагдсан элэгдэл	(21,546,341.68)	(8,513,094.71)
1.2.11	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,831,438,840.01</b>	<b>1,830,192,133.34</b>
1.2.12	Програм хангамж	10,954,400.00	10,954,400.00
1.2.13	Хуримтлагдсан элэгдэл	(9,659,359.99)	(10,906,066.66)
1.2.14	Бусад биет бус хөрөнгө	1,830,143,800.00	1,830,143,800.00
1.2.15	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,545,479,564.72</b>	<b>9,261,647,729.33</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,833,680,629.89</b>	<b>10,517,960,204.99</b>
2.1.1.1	Байгууллагад өгөх өглөг	76,702,911.71	780,769,847.86
2.1.1.2	Хувь хүмүүст төлөх өглөг	1,000,001.11	41,266,939.81
2.1.1.3	Татварын өр	26,029,106.53	102,806,015.47
2.1.1.4	НДШ - ийн өглөг	-	130,056,469.69
2.1.1.5	Банкны богино хугацаат зээл	-	115,916,142.94
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	117,691.93	6,579,378.93
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	8,104,547.41
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>103,849,711.28</b>	<b>1,185,499,342.11</b>
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	79,410,122.79	1,198,818,152.99
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	5,465,046,846.85	5,480,849,250.36
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>5,544,456,969.64</b>	<b>6,679,667,403.35</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>5,648,306,680.92</b>	<b>7,865,166,745.46</b>

<b>2.3.1</b>	<b>Эздийн өмч</b>	<b>1,349,873,387.25</b>	<b>1,349,873,388.25</b>
2.3.1.1	төрийн	1,349,873,387.25	1,349,873,388.25
2.3.4	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	714,691,105.13	646,606,596.52
2.3.6	Эздийн өмчийн бусад хэсэг	3,495,997,951.78	3,495,997,951.78
2.3.7	Хуримтлагдсан ашиг	(2,375,188,495.19)	(2,839,684,476.02)
<b>2.3.9</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>3,185,373,948.97</b>	<b>2,652,793,460.53</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>8,833,680,629.89</b>	<b>10,517,960,204.99</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,700,187,872.45	4,437,465,597.45
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,743,321,930.68	4,647,764,463.71
3	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>-43,134,058.23</b>	<b>-210,298,866.26</b>
4	Түрээсийн орлого	0.00	17,243,399.99
5	Хүүний орлого	500,632.09	216,398.01
6	Бусад орлого	362,876,917.17	413,384,905.08
7	Борлуулалт, маркетингийн зардал	218,693,096.26	299,095,557.93
8	Ерөнхий ба удирдлагын зардал	330,835,702.28	495,770,443.33
9	Бусад зардал	22,678,119.80	3,650,000.00
10	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-251,963,427.31</b>	<b>-577,970,164.44</b>
11	<b>Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>-251,963,427.31</b>	<b>-577,970,164.44</b>
12	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>-251,963,427.31</b>	<b>-577,970,164.44</b>
13	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>17,685,385.00</b>	<b>45,389,675.00</b>
14	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	17,685,385.00	45,389,675.00
15	<b>Нийт дэлгэрэнгүй орлогын дүн</b>	<b>-234,278,042.31</b>	<b>-532,580,489.44</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>2,904,061,447.94</b>	<b>4,561,971,246.22</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,720,504,748.72	3,480,554,799.69
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,623,854.00	9,774,315.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	181,932,845.22	1,071,642,131.53
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>2,814,579,680.57</b>	<b>4,541,755,613.48</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	846,368,747.36	1,459,787,306.46
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	259,330,710.90	343,584,787.44
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	553,458,753.71	485,403,110.31
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	375,674,976.56	374,529,718.03
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	279,810,945.00	641,271,091.73
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	378,922.52	92,233.32
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	211,405,228.67	388,387,814.50
1.2.9	Бусад мөнгөн зарлага	286,287,660.85	848,699,551.69
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>89,481,767.37</b>	<b>20,215,632.74</b>
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>164,794.92</b>	<b>65,784.43</b>
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	164,794.92	65,784.43
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>187,284,400.00</b>	<b>41,027,100.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	181,868,000.00	33,858,400.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,416,400.00	7,168,700.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-187,119,605.08</b>	<b>-40,961,315.57</b>
<b>4.1</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-97,637,837.71</b>	<b>-20,745,682.83</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>140,275,583.53</b>	<b>42,637,745.82</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>42,637,745.82</b>	<b>21,892,062.99</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,349,873,387.25</b>	<b>776,415,842.92</b>	<b>3,495,997,951.78</b>	<b>(2,123,225,067.88)</b>	<b>3,499,062,114.07</b>
3	Залруулсан үлдэгдэл	1,349,873,387.25	776,415,842.92	3,495,997,951.78	(2,123,225,067.88)	3,499,062,114.07
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(251,963,427.31)	(251,963,427.31)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(61,724,737.79)	-	-	(61,724,737.79)
9	<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,349,873,387.25</b>	<b>714,691,105.13</b>	<b>3,495,997,951.78</b>	<b>(2,375,188,495.19)</b>	<b>3,185,373,948.97</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	113,474,183.61	113,474,183.61
11	Залруулсан үлдэгдэл	1,349,873,387.25	714,691,105.13	3,495,997,951.78	(2,261,714,311.58)	3,298,848,132.58
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(577,970,164.44)	(577,970,164.44)
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	113,474,183.61	-	-	113,474,183.61
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	45,389,675.00	-	-	45,389,675.00
17	<b>2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,349,873,387.25</b>	<b>646,606,596.52</b>	<b>3,495,997,951.78</b>	<b>(2,839,684,476.02)</b>	<b>2,652,793,459.53</b>

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**  
Байхгүй

## **Гурав. Аудитын илрүүлэлт:**

### **Завсрын аудитаар илэрсэн алдаа, зөрчил**

2025 оны 3-р улирлын байдлаар хийсэн завсрын аудит хамрагдаагүй байна.

Аудитаар 189,153.5 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илрүүлж аудитын явцад алдааг бүрэн залруулсан.

1. Дахин үнэлсэн 189,153.5 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацаа дуусаж данснаас хасахдаа хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бууруулах бичилт хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 40,589.6 мянган төгрөгийн 7 зөрчил<sup>2</sup> илэрснээс 2,100.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 31,489.6 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 7,000.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

Аудитаар илэрсэн 40,739.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа буюу зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### **3.1 Төлбөрийн акт**

**3.1.1 Илрүүлэлт:** Тайлант онд 9 ажилтанд 2,100.0 мянган төгрөгийн албан томилолтын зардлын хоногийг илүү тооцож олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалтуудыг зөрчсөн.

### **3.2 Албан шаардлага**

**3.2.1. Илрүүлэлт:** Зарлагын төлөвлөгөөг батлуулсан боловч томилолтын зардлыг 6,920.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-т “тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах” гэсэн заалтуудыг зөрчсөн.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Шийдвэрлэсэн нь:** Төлөвлөсөн зардлыг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

**3.2.2. Илрүүлэлт:** Томилолтын зардалд анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар 9,200.0 мянган төгрөгийг олгосон. Томилолтын хуудасны бүрдэл хангалтгүй мөн томилолтоор ажилласан тайлан, удирдамжийг хавсаргаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-т “тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах” гэсэн заалтуудыг зөрчсөн.

**Шийдвэрлэсэн нь:** Анхан шатны баримтын бүрдлийн хангах, томилолтоор ажилласан ажлын гүйцэтгэлийг үнэлж ажиллах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

**3.2.3. Илрүүлэлт:** 11 ажилтны 14,793.6 мянган төгрөгийн цалин хөлсийг НДШ-ийн тайланд дутуу тайлагнасан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-т “тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах” гэсэн заалтуудыг зөрчсөн.

**Шийдвэрлэсэн нь:** Албан хаагчдын цалин хөлсийг НДШ-д үнэн зөв тайлагнах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

**3.2.4. Илрүүлэлт:** ХХОАТ-ын тайланд 5 ажилтны цалин хөлсийг 576.0 мянган төгрөгийг дутуу тайлагнасан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-т “тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах” гэсэн заалтуудыг зөрчсөн.

**Шийдвэрлэсэн нь:** Албан хаагчдын цалин хөлсийг ХХОАТ-ыг бүрэн үнэн зөв тайлагнах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

### **3.3 Зөвлөмж**

#### **5.3.1 Дотоод хяналттай холбоотой**

**3.3.1. Илрүүлэлт** Цалингийн урьдчилгааг дотоод журмын дагуу олгож, суутгалыг 3 сард хуваан суутгал хийхдээ 15 ажилтны 7,000.0 мянган төгрөгийн урьдчилгааг цалингаас суутган тооцоогүйгээс шууд кассанд бэлнээр болон харилцах дансанд орлогоор тушаасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 17 дугаар зүйлийн 17.1.2-т “холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг

зохион байгуулах, хянах”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цалингийн урьдчилгааг тухай бүр цалингаас суутган авч, тайлагнах, цалингийн суутгалыг бэлнээр хүлээн авахгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд буюу тайланг гардаж авснаас 30 хоногийн дотор тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:  
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
УС-ДУ ОНӨААТҮГ	1	189.2			1	189.2	1	189.2				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>189.2</b>			<b>1</b>	<b>189.2</b>	<b>1</b>	<b>189.2</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
УС-ДУ ОНӨААТҮГ	5	40.6	1	2.1	3	33.6	1	7.0				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>40.6</b>	<b>1</b>	<b>2.1</b>	<b>3</b>	<b>33.6</b>	<b>1</b>	<b>7.0</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
УС-ДУ ОНӨААТҮГ	1	37.7			1	37.7		
	1	37.7			1	37.7		
УС-ДУ ОНӨААТҮГ	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>					<b>1</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>37.7</b>			<b>1</b>	<b>37.7</b>	<b>2</b>	<b>-</b>

**Тав.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	ОНӨҮГ	1	1			1			
3	Төсөл, хөтөлбөр								
4	ЗГТС								
5	ТТЗ								
6	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			